



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар A/545

Булган сум

Гэр бүлийн хэрэгцээнд хамтран өмчилсөн
газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчлөх иргэдийн хэлцлийг үндэслэн хамтран өмчлөгчөөс хасагдах, газар өмчлөгчөөр үлдэх өмчлөгчийг хавсралтаар баталсугай.

2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулж, газар ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010366



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/546

Булган сум

Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай


Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2022 оны 03 дугаар срын 29-ний өдрийн IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Нүнжигт өргөө” ХХК (РД:3191958)-ийн Булган сум 5 дугаар баг Д.Дамбын 2 дугаар гудамж 208а тоотод байршилтай 6308009465 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 654 м² газрын зориулалтыг нийтийн орон сууцны зориулалтай болгон өөрчилсүгэй

2. “Нүнжигт өргөө” ХХК-тай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/533 дугаар захирамжийн “Нүнжигт өргөө” ХХК-тай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6308010573